

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ ХҮҮХДИЙГ ХУДАЛДАХ, ХҮҮХДИЙН БИЕЙГ ҮНЭЛЭХ, ХҮҮХДИЙГ САДАР САМУУНД СУРТАЛЧЛАХЫН ЭСРЭГ ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦИД ОРУУЛАХ НЭМЭЛТ ПРОТОКОЛ

2000 оны 5 дугаар сарын 25-ны өдөр

- Энэхүү Протоколын оролцогч улсууд,
 - Хүүхдийн эрхийн тухай конвенцийн зорилтыг цаашид хангах болон түүний заалтуудыг хэрэгжүүлэх үүднээс, ялангуяа 1, 11, 21, 32, 33, 34, 35 болон 36 дугаар зүйлд заасныг хэрэгжүүлэхийн тулд хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх болон хүүхдийг садар самуунд сурталчлах явдлаас хүүхдийг хамгаалах зорилгоор оролцогч улсуудын зүгээс илүү өргөн хүрээний арга хэмжээ авбал зохино хэмээн үзэж,
 - эдийн засгийн дарангуйлал болон эрүүл мэндэд нь аюул учруулах буюу сурч боловсроход нь саад хийх мөн хүүхдийн эрүүл мэнд, бие бялдар, сэтгэл санаа, оюун санаа болон сэтгэл зүй, ёс суртахуун болон нийгмийн хөгжилд хохирол учруулах аливаа хөдөлмөр эрхлүүлэхээс хүүхдийн эрхийг хамгаалах талаар Хүүхдийн эрхийн тухай конвенцид хүлээн зөвшөөрснийг мөн харгалзан үзэж,
 - хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх болон хүүхдийг садар самуунд сурталчлах зорилгоор олон улсын хэмжээнд хууль бусаар хил зувчуулан тээвэрлэх явдал мэдэгдэхүйц нэмэгдэж байгаад гүнээ харамсаж,
 - хүүхдэд аюултай секс аялал өргөжин үргэлжилж, ялангуяа энэ нь хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх болон хүүхдийг садар самуунд сурталчлахад шууд дөхөм үзүүлж байгаад сэтгэл гүнээ зовниж,
 - бага насны охидыг оролцуулан эмзэг бүлгийн хүүхдүүд бэлгийн хүчирхийлэлд илүү өртөж байгаа бөгөөд бэлгийн хүчирхийлэлд өртөгсдийн харьцангуй дийлэнх хувийг бага насны охид эзэлж байгааг хүлээн зөвшөөрч,
 - Интернет болон бусад дэвшилт технологийн хүчээр хүүхдийг садар самуунд сурталчлах явдал нэмэгдэж байгаад сэтгэл зовнин, мөн интернэтээр хүүхдийг садар самуунд сурталчлахтай тэмцэх асуудлаарх бага хурал /Вена, 1999/, ялангуяа түүний хүүхдийг садар самуунд сурталчилсан дүрс бичлэг, зар сурталчилгааг дэлхий нийтээр үйлдэх, тараах, экспортлох, дамжуулах, импортлох, санаатайгаар хадгалах нь гэмт хэрэг гэж үзсэн болон засгийн газрууд, интернэтээр мэдээлэл түгээгчдийн хооронд илүү хамтын ажиллагаа, түншлэл тогтоох нь чухал ач холбогдолтой гэж үзсэн шийдвэрийг иш үндэс болгон,
 - хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх болон хүүхдийг садар самуунд сурталчлах явдлыг арилгахын тулд ийм байдал уруу түлхэж байгаа хүчин зүйлс, тухайлбал буурай хөгжил, ядуурал, эдийн засгийн тэнцвэргүй байдал, нийгэм эдийн засгийн тэгш бус байдал, гэр бүлийн гишүүдийн хоорондын таарамжгүй байдал, боловсролын дутагдал, хот хөдөөгийнхний шилжилт хөдөлгөөн, хүйсээр ялгаварлах байдал, бэлгийн харилцаанд насанд хүрэгчдийн хариуцлагагүй үйлдэл, уламжлалт зан заншлын хортой хэлбэр, зэвсэгт мөргөлдөөн болон хүүхдийг хууль бусаар хил зувчуулан тээвэрлэх зэрэг асуудлыг шийдвэрлэх нь дээрх байдлыг арилгахад тус дөхөм үзүүлнэ гэж үзэж,
 - хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх болон хүүхдийг садар самуунд сурталчлах эрэлт хэрэгцээг багасгахын тулд олон нийтийн дунд мэдээллийг сайжруулах чиглэлээр хүчин чармайлт тавих хэрэгтэй бөгөөд оролцогч бүх талын хооронд даяаршлын түншлэлийг бэхжүүлэх талаар онцгой анхаарч, үндэсний хэмжээнд хуулийн хэрэгжилтийг сайжруулах нь чухал гэж үзэж,
 - хүүхдийг хамгаалахтай холбогдсон олон улсын эрх зүйн баримт бичиг, тухайлбал, Хүүхдийг хамгаалах болон улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай Гаагийн конвенц, Олон улсын хэмжээнд хүүхдийг хууль бусаар зөөхтэй холбогдон үүсэх иргэний асуудлын тухай Гаагийн конвенц, Эцэг эхийн зүгээс хүлээх хариуцлага болон хүүхдийн эрхийг хамгаалах хууль, тэдгээрийг хүлээн зөвшөөрөх, мөрдүүлэх болон хамтран ажиллах тухай Гаагийн конвенц болон Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг хориглож устгах тухай Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 182 дугаар конвенцийн заалтыг анхааралдаа авч,
 - хүүхдийн эрхийг хамгаалах болон дэмжлэг үзүүлэх үйл хэрэгт бүх талаар үйлчилж буй Хүүхдийн эрхийн тухай конвенцийг бүх нийтээрээ дэмжиж байгаад урамшин,
 - Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх болон хүүхдийг садар самуунд сурталчлахыг таслан зогсоох үйл ажиллагааны хөтөлбөрийн заалт болон Арилжааны зорилгоор хүүхдийг бэлгийн хүчирхийлэлд ашиглахын эсрэг 1996 оны наймдугаар сарын 27-оос 31-ний өдрүүдэд болсон Дэлхий дахины их хурлын тунхаглал болон үйл ажиллагааны төлөвлөгөө, холбогдох бусад олон улсын байгууллагаас энэ асуудлаар гаргасан шийдвэр, зөвлөмжийг хэрэгжүүлэх нь чухал болохыг хүлээн зөвшөөрч,
 - хүүхдийг хамгаалах, өв тэгш хөгжүүлэх талаар ард түмнүүдийн зан заншил, соёлын үнэт зүйлсийг чухалчлан, зохих ёсоор харгалзан үзэж,
 - дараахь зүйлийг хэлэлцэн тохиролцов:
 - 1 дүгээр зүйл
 - Энэхүү Протоколд зааснаар оролцогч улсууд хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх болон хүүхдийг садар самуунд сурталчлахыг хориглоно.
 - 2 дугаар зүйл
 - Энэхүү Протоколын зорилгод:
 - (a) хүүхдийг худалдах гэж аливаа этгээд буюу бүлэг этгээд шан харамж буюу бусад аливаа төлбөр авч хүүхдийг бусад этгээд буюу бүлэг этгээдэд шилжүүлэн өгөх аливаа үйлдэл буюу хэлцлийг хэлнэ;
 - (b) хүүхдийн биеийг үнэлэх гэж шан харамж буюу бусад аливаа төлбөрийн хэлбэрээр хүүхдийг бэлгийн харилцаанд ашиглахыг хэлнэ;
 - (c) хүүхдийг садар самуунд сурталчлах гэж хүүхдийг ил тод бэлгийн харилцаанд бодитоор буюу хиймлээр оруулж байгааг аливаа арга хэрэгслээр илэрхийлэх буюу гол нь бэлгийн харилцааны зорилгоор хүүхдийн бэлэг эрхтнийг аливаа байдлаар харуулахыг хэлнэ.
 - 3 дугаар зүйл
 - 1. Оролцогч улс бүр эрүүгийн болон гэмт хэргийн талаархи хуулиндаа дор хаяж дараахь үйлдэл болон үйл ажиллагааг бүрэн хамааруулж, эдгээр гэмт хэрэг улсын дотоодод буюу үндэстэн дамнасан болон ганцаарчилсан буюу зохино байгуулалттай хэлбэрээр үйлдэгдсэнийг харгалзахгүйгээр хариуцлага хүлээлгэх талаар:
 - (a) 2 дугаар зүйлд тодорхойлсон хүүхдийг худалдахтай холбогдуулан:
 - (i) хүүхдийг аливаа арга хэрэгслээр дараахь зорилгоор санал болгох, шилжүүлэх буюу авах:

- a. бэлгийн хүчирхийлэлд ашиглах;
- b. шан харамж авч хүүхдийн эрхтэнг шилжүүлэх;
- c. хүүхдийг албадан хөдөлмөр эрхлүүлэхэд ашиглах;
- (ii) хүүхэд үрчлэх үйл ажиллагаанд зуучлахдаа хүүхэд үрчлэх тухай олон улсын эрх зүйн баримт бичгийн заалтыг зөрчиж хууль бус арга хэрэглэн зөвшөөрүүлэх,
- (b) 2 дугаар зүйлд тодорхойлсны дагуу хүүхдийн биеийг үнэлэх зорилгоор хүүхдийг санал болгох, авах, шилжүүлэх болон өгөх;
- (c) 2 дугаар зүйлд тодорхойлсны дагуу дээрх зорилгод ашиглахаар хүүхэд оролцсон садар самуун сурталчилгааг үйлдэх, түгээх, тараах, импортлох, санал болгох, худалдах буюу хадгалах.
- 2. Оролцогч улсын үндэсний хууль тогтоомжийн заалтаас хамааран эдгээр үйлдлийн аль нэгийг хийхээр оролдсон, хамтран оролцсон буюу оролцсон тохиолдолд дээрх заалт мөн адил үйлчилнэ.
- 3. Эдгээр гэмт хэргийн гэм хор үзүүлсэн зэрэглэлийг харгалзан оролцогч улс бүр зохих шийтгэл ногдуулна.
- 4. Оролцогч улс бүр үндэсний хууль тогтоомжийн заалтаас хамааран энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг хуулийн этгээд үйлдсэн бол түүний хүлээх хариуцлагыг тогтоох талаархи арга хэмжээг зохих үед авна. Оролцогч улсын эрх зүйн зарчмаас хамааран хуулийн этгээдийн хариуцлага нь эрүүгийн, иргэний болон захиргааных байж болно.
- 5. Оролцогч улсууд хүүхэд үрчлэх асуудалтай холбогдсон бүх этгээд олон улсын эрх зүйн баримт бичигт тусгасан хэм хэмжээний дагуу үйл ажиллагаа явуулахад зориулж эрх зүйн болон захиргааны холбогдох арга хэмжээ авна.

4 дүгээр зүйл

- 1. Оролцогч улс бүр 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан гэмт хэргийн хувьд тухайн гэмт хэрэг түүний нутаг дэвсгэрт буюу далайн боомтод, эсхүл уг улсад бүртгэлтэй агаарын хөлөгт үйлдэгдсэн тохиолдолд өөрийн шүүх эрх мэдлийг тогтоохоор зайлшгүй гэж үзсэн арга хэмжээ авч болно.
- 2. Оролцогч улс бүр 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан гэмт хэргийн хувьд өөрийн шүүх эрх мэдлийг тогтоохоор зайлшгүй гэж үзсэн арга хэмжээ дараахь тохиолдолд авч болно:
 - (a) хэрэгтэн тухайн улсын иргэн буюу уг этгээдийн оршин суугаа газар тухайн улсын нутагт дэвсгэрт байрладаг бол;
 - (b) хохирогч тухайн улсын иргэн бол.
- 3. Оролцогч улс бүр дээр дурдсан гэмт хэргийн хувьд өөрийн шүүх эрх мэдлийг тогтоохоор зайлшгүй гэж үзсэн арга хэмжээг тухайн хэрэгтэн түүний нутаг дэвсгэрт байгаа болон гэмт хэргийг түүний иргэн үйлдсэн гэсэн үндэслэлээр уг улс хэрэгтэнг оролцогч өөр улсад шилжүүлэхгүй байх арга хэмжээ авч болно.
- 4. Энэхүү Протокол нь дотоодын хууль тогтоомжийн дагуу хэрэгжиж буй эрүүгийн аливаа хуулийн эрх мэдлийг хязгаарлахгүй.

5 дугаар зүйл

- 1. 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэгчийг оролцогч улсуудын хооронд байгуулсан хэрэгтэн шилжүүлэн өгөх тухай аливаа гэрээнд шилжүүлж өгөх хэрэгтэнд оруулан тооцох бөгөөд тэдгээрийн хооронд цаашид байгуулах хэрэгтэн шилжүүлэх тухай аливаа гэрээнд тухайн гэрээнд заасан нөхцлийн дагуу шилжүүлж өгөх хэрэгтэнд хамааруулан авч үзнэ.
- 2. Хэрэв оролцогч улс нь хэрэгтэн шилжүүлж өгөх гэрээний үндсэн дээр хэрэгтэн шилжүүлж өгөх гэрээ байгуулаагүй оролцогч өөр улсаас хэрэгтэнг шилжүүлэх талаар хүсэлт гаргавал тухайн улс энэхүү Протоколыг хэрэгтэн шилжүүлэх эрх зүйн үндэс хэмээн үзэж болно. Хэрэгтэнг хүсэлт хүлээж авсан тухайн улсын хуульд заасан нөхцлийн дагуу шилжүүлнэ.
- 3. Хэрэгтэнг шилжүүлж өгөх гэрээ байгуулаагүй оролцогч улсууд өөр хоорондоо тухайн гэмт хэрэг үйлдэгчийн хувьд хүсэлт хүлээж авсан улсын хуульд заасан нөхцлийн дагуу шилжүүлж өгөх хэрэгтэн хэмээн үзнэ.
- 4. Оролцогч улсуудын хооронд хэрэгтэн шилжүүлэх асуудлын тухайд гэмт хэргийг зөвхөн уг хэрэг гарсан газрын хэмжээнд бус 4 дүгээр зүйлийн дагуу өөрсдийн хууль эрх мэдлийн хүрээг тогтоовол зохих улсын нутаг дэвсгэр дээр гарснаар авч үзнэ.
- 5. Хэрэв хэрэгтэнг 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан гэмт хэргийн аль нэгтэй холбогдуулан шилжүүлж авах тухай хүсэлт гаргасан бөгөөд хүсэлт хүлээж авсан оролцогч улс хэрэгтнийг харьяаллын үндсэн дээр шилжүүлж өгөөгүй буюу өгөхгүй бол түүнийг эрүүгийн хэрэгт шалгуулахаар гэмт хэргийг өөрийн эрх бүхий байгууллагад шилжүүлэх талаар зохих арга хэмжээ авна.

6 дугаар зүйл

- 1. Оролцогч улсууд 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн тухайд хэрэгтэнг илрүүлэх буюу эрүүгийн хэрэгт шалгах буюу түүнийг шилжүүлэх үйл ажиллагаатай холбоотой асуудлаар харилцан бие биедээ бүхий л бололцоогоор туслах бөгөөд дурдсан байцаан шийтгэх ажиллагааг явуулахад шаардлагатай нотлох баримтыг олоход мөн тусална.
- 2. Оролцогч улсууд энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үүргээ биелүүлэхдээ өөр хоорондоо байгуулсан эрх зүйн туслалцаа үзүүлэх аливаа гэрээ буюу бусад тохиролцоог удирдлага болгоно. Ийм гэрээ буюу тохиролцоо байхгүй бол оролцогч улсууд дотоодын хууль тогтоомжийн дагуу өөр хоорондоо туслалцаа үзүүлнэ.

7 дугаар зүйл

Оролцогч улсууд үндэсний хууль тогтоомжид заасны дагуу:

- (a) шаардлагатай үед дор дурдсан зүйлийг хураах болон дайчлах арга хэмжээ авна:
 - (i) энэхүү Протоколд заасан гэмт хэргийг үйлдэхэд ашиглаж байсан буюу гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэж байсан эд хөрөнгө, материал, хэрэгсэл болон багаж зэвсэг;
 - (ii) тухайн гэмт хэрэг үйлдэж олсон орлого;
- (b) (a) дэд хэсгийн (i)-д заасан эд хөрөнгө болон орлогыг хураах буюу дайчлах тухай оролцогч нөгөө улсын хүсэлтийг биелүүлнэ;